



Published in the Russian Federation  
Bulletin of the Kalmyk Institute for Humanities  
of the Russian Academy of Sciences  
Has been issued since 2008  
ISSN: 2075-7794; E-ISSN: 2410-7670  
Vol. 23, Is. 1, pp. 50–58, 2016  
DOI 10.22162/2075-7794-2016-23-1-50-58  
Journal homepage: <http://kigiran.com/pubs/vestnik>

UDC 94(517)

## **Mining Industry in Mongolia and its Place in the State Policy (from 1911 to 1919)**

Yangugiyn Sodbaatar<sup>1</sup>

<sup>1</sup> Post-graduate Student at Mongolian State University of Education (Ulaanbaatar, Mongolia).  
E-mail: [ya\\_sod5@yahoo.com](mailto:ya_sod5@yahoo.com)

### **Abstract**

After gaining the independence, Mongolia, in the period of 1911–1919, carried out an independent policy aimed at reviving the national economy. An important policy direction of the Mongolian government in this area was considered to be the exploitation of wealth and natural resources, the proceeds from which were to be the source of the solution of financial difficulties. In these circumstances, the government of the country took concrete measures such as drafting legislative acts, entering into contracts and contracting with the company “Mongolor” and Russian entrepreneurs for the development of gold mines and increase of tax for the exploitation of the country’s wealth. All this though did not bring big economic benefits, but contributed significantly to the strengthening of national interests of the Mongolian state.

**Keywords:** independence, the bowels of the earth, public revenues, ore mining, gold mining, “Mongolor”.

1911 онд тусгаар тогтнолоо сэргээсэн Монгол улс санхүүгийн хувьд хүндхэн сорилт туулсан юм. Монгол улсын Засгийн газар уг сорилтыг давахын тулд Хаант Орос улсаас зээллэг авахын зэрэгцээ дотоод нөөц бололцоогоо ашиглах, орлогын үндсэн эх сурвалж болох гааль, татварт голлон анхаарсан ч тэдгээрээс төвлөрөх хөрөнгө мөнгө тус улсын санхүүгийн зардлыг нөхөж дийлэхгүй байлаа. Иймд орлогын өөр эх сурвалж нэмэн олж засаг захиргаа, цэрэг, орон нутгийн олон зардлыг санхүүжүүлэх шаардлагатай тулгарчээ.

Манж Чин гүрний эрхшээлд гадаад ертөнцөөс бүрэн тусгаарлагдаж ирсэн Монгол орон тухайн цагийнхаа аж үйлдвэр, боловсрол, соёл, шинжлэх ухааны хөгжлөөс хол хоцорсоны улмаас санхүүгийн талаар хөл дээрээ босоход дорвитой нөлөө үзүүлэхүйц аж ахуйн салбар үндсэндээ байсангүй. Харин 1900 оноос Манж Чин улсын хааны зөвшөөрлөөр Түшээт хан, Сэцэн хан аймгийн нутагт үйл ажиллагаа явуулсан «Монголор» нийгэмлэгийн алт олборлолтод татвар оногдуулах нь богино хугацаанд багагүй хөрөнгө мөнгө босгох арга зам байв.

Монголын эрх нөлөө бүхий хүмүүс ч газрын хэвлийн баялаг, ялангуяа алтыг олборлож, санхүүгийн нэг эх үүсвэрээ болгохыг нилээд эртнээс төлөвлөж байсан бололтой. Тухайлбал, 1911 онд Гадаад Монголын ноёд, лам нар тусгаар тогтнолын тэмцэлдээ Хаант Орос улсаас тусламж эрсэн бичгийг дагалдуулж илгээсэн 21 зүйл бүхий бичигтээ «...Манай Монгол Их улсыг түшиж бага улс болон өөртөө тогтнож болох болбол нууц болзоо гэрээ бичиг байгуулж хэн алиныг бат итгэмжийг илрүүлж болох ба...тэр гэрээнд Монголын газар яахин Оросын худалдаа гүйлгээ, төмөр зам хийх өртөө байгуулах, алт мөнгө зоорь нээлгэх...зэрэг зүйлийг хэлэлцэж тогтоох» санал тавьж байв [МХТТЭ 2010: 22].

Тиймээс Монгол улсын Засгийн газар байгуулагдсан цагаасаа ашигт малтмалын асуудлыг чухлаар авч үзсэн байна. Халхын Хүрээний Бүх Хэргийг Түр Ерөнхийлэн Шийтгэх Газрын 1911 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн шийдвэрээр их төлөв Манж Чин улсын алба нэвтрүүлэх үүрэгтэй олон замын өртөө, харуулаас зохихыг үлдээж, бусдыг буулгахдаа «зүүн хоёр аймгаас хэлтгий суулгасан алт гаргах газар» зэрэг чухал хэрэглэгдэх харуул болон өртөөдийг хэвээр үлдээхээр тогтоожээ [МАТҮЭЧТТТТ 1982: 116–117]. Ийн Монголын Засгийн газар ну-

таг орныхоо баялгийг хяналтандаа оруулж, хамгаалах арга хэмжээг эн түрүүнд авчээ.

1912 оны 12 дугаар сарын 29-нд Монгол улс тусгаар тогтнолоо зарлан VIII Богд Жавзүандамбыг хаан ширээнд залж, Засгийн газрыг 5 яамтайгаар байгуулав. Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яаманд аливаа дотоод засгийн үндсэнд холбогдох хэргийг эрхлэн захирч, ...улсын шастир, хууль «зүйл, гэрээ бичиг, өрх амын данс, газар орны зургийг хадгалж зах хязгаар нутаг үндсэнд холбогдох хэрэг, өртөөний засгийг эрхлэх» эрх, үүрэг оногдсон байна [Батбаяр 2011: 33]. Үүгээр тус яам дотоод бодлогыг нэгтгэн зангидаж явуулах болсны дотор хууль зүйл, гэрээ бичигт холбогдох буюу газрын хэвлийн баялгийг ашиглах, ашиглуулах асуудал багтжээ. Гэхдээ уул уурхайн зарим чухал гэрээг боловсруулж байгуулахад Дотоод, Гадаад болон Сангийн хэрэг эрхлэх яамд хамтран оролцож байлаа.

1912 оны сүүлээр Бүгд Ерөнхийлэн Захирах Яам байгуулагдсаны дараа газрын хэвлийн баялгийн асуудлыг Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яаманд шилжүүлжсэн нь Монгол улсад уул уурхай эрхлэгчдийн дийлэнх гадаад хүмүүс байсантай холбоотой. Ийнхүү Монголын төрөөс газрын хэвлийн баялгийн талаарх асуудлыг Засгийн газрыг ахлах Дотоод яам, улмаар дэд буюу Гадаад яаманд хариуцуулан уг салбарт багагүй анхаарал хандуулж байв.

Монгол улс уг зорилтыг өөрийн хүч нөөцөөр хэрэгжүүлэх боломжгүй байсны дээр Хаант Орос улсын улс төр, эдийн засгийн ашиг сонирхолтой зөрчилдсөн нь гол нөлөөг үзүүлжээ. Хаант Орос улс Монгол улсын нутаг дахь алт олборлолтын асуудлыг тус оронд эдийн засгийн нөлөөгөө тогтоох зорилтын хүрээнд шийдвэрлэхийг зорьж байв. Үүнийг Оросын төрийн зүгтэлтэн С. Ю. Витте Монголд гадныхан алт олборлох явдлыг явч хүлээн зөвшөөрч болохгүй хэмээн Гадаад хэргийн яамны сайд Н. М. Муравьевт бичсэн захидалдаа тэмдэглэснээс харж болно [Урангуа 2010: 46]. Хаант Орос улсын Засгийн газар Монгол дахь алт олборлолтоо бусад улсад алдалгүй, лавшруулахыг эртнээс хичээж иржээ. Тухайлбал, «Монголор» нийгэмлэг 1904 оны байдлаар 666889 рублийн өртэй болж үйл ажиллагаа нь доголдоход Хаант Орос улсын Засгийн газар тус нийгэмлэгийн үйл ажиллагааг зогсоохгүйн тулд 50000 рублийн зээллэг өгч байсан [Туяа, Баттөмөр 2012: 62] нь Орос улс хэдийгээр Японтой дайтаж

байсан ч Монгол дахь алт олборлолтод тавих анхаарлаа сулруулаагүйг харуулна.

Эл нөхцөлд тусгаар тогтносон Монгол улс хувьд газрын хэвлийн баялгийг ашиглах талаар бие даасан бодлого явуулж, «Монголор» нийгэмлэг, бусад алт олборлогчидтой гэрээ хэлцэл байгуулах нь тулгамдсан асуудал болжээ. Тухайн үед ганц «Монголор» нийгэмлэг жилдээ 120 пүд алт олборлож байснаас үзэхэд тухайн асуудал дөнгөж байгуулагдсан Монгол улсын санхүүгийн хувьд нэн чухал бөгөөд хойшлуулшгүй зорилт байсан нь тодорхой. Гэрээ хэлцэл хийх нь улс төрийн талаар ч багагүй ач холбогдолтой байлаа.

Энэ бүх шалтгаанаар Монгол улсын Засгийн газар «Монголор» нийгэмлэг болон бусад алт олборлогчидтой гэрээ байгуулах, уурхайн тоог нэмэгдүүлэх, алт олборлолтоос татвар авч санхүүдээ нэмэрлэх бодлогыг явуулав.

1911 оны эцсээр Монголын Засгийн газар тусгай шийдвэр гаргаж, «Монголор» нийгэмлэгт үйл ажиллагаагаа үргэлжүүлэхийг зөвшөөрсөн [Туяа, Батгөмөр 2012: 79] бөгөөд чингэхдээ Дотоод яамны тэргүүн сайд Г. Цэрэнчимэд тус нийгэмлэгээр 50 мянган рубль төлүүлж харуулуудын нутагт алт олборлох эрхийг олгожээ [Котвичийн 1972: 174]. Тэрээр мөн «Монголор» нийгэмлэгийн гэрээг хянаж, түүнээс авах татварыг ахиулах саналаа Оросын консул, нийгэмлэгийн захиргаанд тавьсан [Содбаатар 2013: 92] нь Монгол улсын Засгийн газар дотоод бодлогоо явуулахдаа бие даах шугам баримталж байсныг илтгэнэ [Сандаг 1971: 278].

Эл үйл ажиллагаа нь Монголд улс төр, эдийн засгийн нөлөөгөө бэхжүүлэх гэсэн Хаант Оросын бодлогод харшилсан учир Нийслэл Хүрэн дэх Орос улсын консулаас «Дан ганц Орос улстай гэрээ» байгуулахыг Дотоод яамны тэргүүн сайд Г. Цэрэнчимэдэд эртнээс тулгаж [Котвичийн 1972: 78], улмаар «...гурав дахь этгээдэд концесс өгөх аваас Орост найртай бус хандсан хэрэг» гэж үзнэ хэмээн сүрдүүлж байв [Содбаатар 2013: 93].

Түүнчлэн Да лам Цэрэнчимэдийн «Монголор» нийгэмлэгийн алт олборлолтын талаар гаргасан шийдвэрийг консул В. Ф. Люба цуцлахыг оролдсоноос тэдний харилцаа мууджээ [Котвичийн 1972: 174]. Тэдний зөрчлийг ашиглан Ф. Москвитин зэрэг хүмүүс Баруун Монголд алт олборлохоор эрх мэдэл бүхий хүмүүстэй хэлцэл хийсэн боловч Оросын харьяат худалдаа,

үйлдвэрлэл эрхлэгч нарт давуу байдал бий болохоос болгоомжилж зөвшөөрөөгүй байна. Харин М. Лушников гэгч консул В. Ф. Любатай өрсөлдөж байсан Хиагтын комиссар А. Д. Хитровоор зуучлуулан Сайн ноён хан аймгийн нутагт алт олборлох эрхийг Монголын талаас авч чаджээ. Чингэж Оросын консул В. Ф. Люба «Монголор» нийгэмлэгийн эрх ашгийг, түүний өрсөлдөгч А. Д. Хитрово Оросын харьяат хувиараа алт олборлогчдын эрх ашгийг хамгаалж, Монгол улсын алт олборлолтын талаар бодлого, үйл ажиллагаанд тус тусын эрх ашгийг эн тэргүүнд тавьж байв. Тэгвэл Монгол улсын Засгийн газар хэдий санхүүгийн хүнд байдалд байсан ч Оросын алт олборлогчдод нөхцөл болзол тавих, зарим саналаас татгалзах зэргээр тэдэнд давуу байдал өгөхгүйг хичээж, эрх тэгш харилцаа үүсгэхийг эрмэлзэж байжээ. Үүний зэрэгцээгээр Нийслэл Хүрэн дэх «Монголор» нийгэмлэгийн төлөөлөл болох фон Грот Чингийн үеийн хэлэлцээрийг хэвээр баримталж [Котвичийн 1972: 127], нийгэмлэгийн алтны уурхайн үйл ажиллагааг зогсооно хэмээн мэдэгдсэн [Туяа, Батгөмөр 2012: 84] нь нөхцөл байдлыг улам хүндрүүлж байв. Гэвч Оросын Засгийн газар «Монголор»-ын хувьцааг худалдан авсан [Урангуа 2010: 64] нь хэлэлцээ цааш үргэлжилж, үр дүнд хүрэхэд нөлөөлсөн бололтой. Фон Грот «Монголор» нийгэмлэгийн алтны уурхайн ажлаас огцрох хүсэлтээ гарган Петербург буцжээ [Ширэндэв 1999: 56].

Энэ нь Монгол улсын Засгийн газар алт олборлолтын талаар бие даасан бодлого явуулахад дөхөм болсон ч алт олборлуулах эрх олгох, олборлолтоос авах татварыг ахиулж улсын орлогоо нэмэгдүүлэх гэсэн Монголын бодлого, зорилт хаант Орос улсын шахалтад оржээ. Тодруулбал, Орос улс Монголын засаг захиргаа, цэргийн зардлаа дийлэхгүй байдлыг ашиглан 100 мянган рублийг алтны уурхайгаас хураах татварын орлогоор 10 жилийн хугацаанд барагдуулах гэрээг 1912 оны 4 дүгээр сарын 25-нд байгуулжээ [Лонжид 2011: 320]. Үүгээр тус улс Монголын алтны татварын орлогыг зээлийн төлбөрөөр дамжуулан хянах боломжтой болов. Энэ гэрээний дараа Монгол улсын Засгийн газар, Хаант Оросын элчин консулын хооронд «Монголор» нийгэмлэгийн тухай хэлэлцээр үргэлжилжээ.

Монгол улсын Дотоод, Гадаад, Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэгч

яамны сайд нар Оросын консултай хэдэнтээ хэлэлцсэний дүнд 1912 оны 5 сард тохиролцоонд хүрч [МУУТА. ФА-3. Д-1. Хн-20], Монголын Засгийн газар, Орос улсын консул хооронд «*Монголорын алтны уурхайн хэрэг Орос консул лугаа зөвлөлдөж шийтгэн тогтоосон гэрээ бичгийн хорин хоёр зүйл*» гэрээ байгуулагдсан байна. Энэ нь Монгол улс тусгаар тогтнолоо зарласнаас хойш Хаант Орос улстай анхны томоохон гэрээг байгуулж чадсан хэрэг болох бөгөөд гэрээгээр «Монголор» нийгэмлэгийн Монгол улс дахь газрын хэвлийн баялгийн олборлолтын үйл ажиллагааг зохицуулах болжээ.

Монгол улсын Засгийн газрын сайд Цэрэнчимэд, Ханддорж, Чагдаржав нарын зүтгэлтнүүдийн хүчин чармайлтаар уг баримт бичигт Монголын төрийн газрын хэвлийн баялгийг ашиглахад баримтлах бодлого, зорилт тусгалаа олсон байна. Эн түүрүүнд тэмдэглэх зүйл бол газрын хэвлийн баялгийг хайх, нөөц тогтоох, нээж ашиглахад Монгол улсын холбогдох яамдын зөвшөөрөлтэйгээр явуулах ба олборлосон алтнаас гэрээнд заасан хувийг тус улсын санд тушаах, хэрэв уг гэрээг зөрчсөн бол нутгаасаа албадан гаргах хүртэл арга хэмжээг авах зэргээр эрх зүйн үндсийг бүрдүүлсэн явдал болно.

1912 оны 11 сарын 3-нд Орос-Монголын Найрамдлын гэрээ бичиг байгуулагдаж, хоёр улсын харилцааны үндсэн зарчмыг тогтоож өгсөн билээ. Уг гэрээгээр Орос улс нь Монголын бие даасан байдлыг бататгахад туслан дэмжих ба тус улсын нутагт эдийн засгийн онц эрхийг олж авчээ. Тодруулбал, тус гэрээ, түүний хавсралтаар худалдаа, үйлдвэрлэл эрхлэх, гаалиас чөлөөлөгдөх болон ой мод, ан агнуур зэрэг баялгийг ашиглах тухайд Орос улсын харьяат нар давуу эрх эдлэх болсон юм [Батсайхан 2002: 262–267].

Харин тус гэрээгээр Монгол улсын Засгийн газар Оросын харьяат нарт газрын хэвлийн баялаг ашиглахад давуу эрх олгосонгүй. Энэ нь дээр дурдсан 22 зүйл баримт бичигтэй холбоотой. Тус гэрээгээр Монгол улс газрын хэвлийн баялгийг олборлолтод баримтлах байр суурь, зарчмаа тодорхойлж, түүнийг Оросын тал зөвшөөрсөн тул тус улсын харьяат бусад уул уурхай олборлогчид ч уг баримт бичгийн хүрээнд гэрээ байгуулж ажиллах эрх зүйн үндэс бүрдсэн тул «Орос-Монголын Найрамдлын гэрээ бичиг»-т газрын хэвлийн баялгийн асуудал тусгагдаагүй болно.

1912 онд байгуулсан эл хоёр гэрээг шинжилвээс, Монгол улсын Засгийн газар нь тус улсын газрын хэвлийн баялгийг давуу эрхээр ашиглах гэсэн Хаант Оросын зорилгод зохих няцаалт өгсөн байна. Чингэснээр Монгол улс нутаг дэвсгэртээ гадаад олон орны уул уурхай эрхлэгчдэд нээлттэй, тэгш боломж нөхцөл олгох бодлогоо хамгаалж үлджээ.

Үүний дараа Монгол улсын Засгийн газар дотоод, гадаадын уул уурхай эрхлэгчидтэй гэрээ байгуулан нутагтаа ажиллуулах болсон билээ. Ингэхдээ Монголын төрөөс тусгайлан дүрэм гаргаж, уул уурхай эрхлэгчидтэй байгуулах гэрээний нийтлэг асуудлуудыг зохицуулах бодлого баримталсан юм.

Монгол улсын Гадаад яамнаас хязгаарын *доторхи «Олон зүйлийн уурхай нээн шийтгүүлэх дүрэм»*-ийг боловсруулан Богд хаанд айлтгаж 1913 оны 9 сарын 19-нд батлуулжээ [МУУТА. ФА-4. Д-1. Хн-2326]. Уг дүрмийг өмнөх 22 зүйлийн гэрээг үндэс болгон боловсруулсан ч агуулгыг өргөтгөж, улам лавшруулж өгчээ.

Дүрмийн 1-р зүйлд «Тус улсын ба Орос улс жич бусад аль ч улсын хүн манай Монгол улсын харьяат газар уурхай нээсүгэй» [МУУТА. ФА-4. Д-1. Хн-2326] хэмээн зааж, нээлттэй зарчмаар дотоод, гадаадын хөрөнгө бүхий хүмүүст газрын хэвлийн баялгийг ашиглуулах зорилт тавьжээ. Тухайн үед Монгол улс Франц, Англи, Герман, АНУ, Бельги, Япон, Дани, Голланд, Австри зэрэг улсад ноот бичиг илгээн харилцаа тогтоож, гэрээ байгуулан худалдаа, үйлдвэрийг нь нутагтаа нэвтрүүлэхийг эрмэлзэж байв. Гадаад улс орны компаниуд, хөрөнгөтнүүд ч Монголын баялгаас хүртэхийг сонирхож байсан учир энэхүү хоёр талын ашиг сонирхлыг бодит ажил хэрэг болгох нь улс төр, эдийн засгийн ач холбогдолтой байлаа. Чухам үүний учир дүрэмд нээлттэй зарчмыг тусгасан бөгөөд энэ нь гадаад улсуудын хөрөнгө хүчийг уул уурхайд татах, хоёр хөршийн улс төр, санхүүгийн дарамт шахалтыг сааруулах гэсэн Монгол төрийн алсыг харсан бодлого байжээ.

Нээлттэй зарчмын зэрэгцээгээр Монгол улсад уул уурхай эрхлэгчдэд үйл ажиллагаа явуулах тэгш нөхцлийг бүрдүүлэхэд ч мөн анхаарчээ.

Харин «Монголор» нийгэмлэг алтны татвар дээр Монгол улстай байгуулсан гэрээний дагуу давуу эрх эдэлж, Оросын харьяат нар «Найрамдлын гэрээ»-нд заасан

ёсоор алтны гаалийн татвараас чөлөөлөгдөж байв. Эдгээрээс бусдаар газрын хэвлийн баялгийг ашиглах зөвшөөрөл авах, хайх, нөөц тогтоох, олборлох, түрээс, татвар төлөх, гэрээнд нэмэлт, засвар оруулах, дуусгавар болгох зэрэг асуудлаар уул уурхай эрхлэгчдэд тэгш нөхцөл, шаардлага тавьжээ. Үүний дүнд Монгол улсын нутаг дэвсгэрт уул уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааг эрх зүйн нэгдмэл харилцаагаар зохицуулах боломж бүрдсэн байна.

Дүрэм батлагдсанаас хойш Монголд М. Лушников, И. Д. Сеницын, К. В. Титов, Ф. Б. Голиков, А. Петров, А. Позднеев, О. Сулеймейнов зэрэг Оросын харьяат нар дангаар болон хамтарч уурхай нээж ажиллуулахдаа үндсэндээ уг дүрмийн хүрээнд гэрээ байгуулжээ. Ийнхүү Монгол улсаас «Монголор» нийгэмлэгтэй гэрээ байгуулах үйл явцад тус улсын газрын хэвлийн баялгийн талаарх бодлого, ашиглахад мөрдөгдөх дүрэм хэмжээ зохих хэмжээнд боловсорсон байна.

Монгол улсын тусгаар тогтнолыг хавчиж байсан Хятад, Орос улсууд 1913 оны 11 сарын 5-нд Монголын талаар тунхаг бичиг гарган Дундад Иргэн улсын Гадаад Монголыг хэмжээтэй эзэрхэхийг харилцан баталж, Гадаад Монголын хязгаар доторхи дотоод засаг ба худалдаа, үйлдвэрийн хэргээ эрхлэх эрхийг зөвшөөрчээ. Мөн 1912 оны Найрамдлын гэрээ, түүний хавсралт хэлэлцээрийг Хятад хүлээн зөвшөөрсөн байна.

Тус хэлэлцээрийн дараа талууд нот солилцсон бөгөөд хоёр талын нот бичгийн 2-р зүйлд Гадаад Монголын засгийг засах ба газар дэлхий, гадаадтай холбогдох хэргийг Дундад улсаас Орос улсын Засгийн газартай зөвлөх, мөн Гадаад Монгол тэр хэрэгт зөвлөлдөх эрхийг зөвшөөрсөн байна [Батсайхан 2002: 271–273]. Ийнхүү баримт бичигт газар нутагт холбогдох аливаа асуудлыг бие даан шийдвэрлэх Монголын эрхийг устгах хоёр хөршийн бодлого илрэлээ олжээ.

Тунхагт заасан эрх хэмжээг Монгол улс 1915 оны Хиагтын гурван улсын гэрээгээр аргагүй хүлээн зөвшөөрсөн юм. Хиагтын гэрээний 3-р зүйлд «Автономит Монгол гадаад улсуудтай газар нутгийн талаар олон улсын хоорондох гэрээ хэлэлцээр байгуулах эрхгүй» хэмээгээд үүнд холбогдох хэрэгт 1913 оны Орос, Хятад улсын хооронд солилцсон нот бичгийн 2-р зүйлийг баримтлахаар заажээ [Батсайхан 2002: 224]. Тодруулбал, Автономит Монголын газар

нутагтай холбоотой гэрээ хэлцлийг олон улстай байгуулах эрхийг хасч, худалдаа ба үйлдвэрийн талаар гадаад улстай гэрээ хэлэлцээр байгуулах эрхийг үлдээжээ.

1913 оны тунхаг болон Хиагтын гэрээний «газар дэлхий», «үйлдвэр» гэх ойлголтуудад уул уурхай хамаарахгүй. Гэрээнд «газар дэлхий» гэдгээр Автономит Монголын нутаг дэвсгэр, хил хязгаарыг илэрхийлж, «үйлдвэр» үгэнд түүхий эд боловсруулах ба аж үйлдвэрийн салбарыг багтаасан гэж болно. Өөрөөр хэлбэл, Хиагтын гэрээнд Гадаад Монголын нутаг дэвсгэр дэх уул уурхайн буюу газрын хэвлийн баялгийг олборлох асуудал тусаагүй байна.

Монгол улс газрын хэвлийн баялгийг зөвшөөрөлгүй хайх, ашиглах явдалд тавих төрийн хяналтыг сайжруулах зорилгоор хариуцлага алдагсдад хүлээлгэх ял шийтгэлийг чангатгаж байв. Үүний тод жишээ нь тус улс «Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг» хэмээх 65 дэвтэр төрөлжүүлэн нэгтгэсэн суурь хуулийг баталж [Батбаяр 2011: 7], түүнд уул уурхай, эрдэс баялгийн асуудлыг тусгаж өгсөн явдал мөн.

Хуулийн 10 дугаар дэвтэрт алт ба мөнгөний зэргийн ордыг түшмэл гаргаж байцаан барьж байх буюу хянахыг олон харьяат засгуудад үүрэг болгон, «...хэрэв тэрхүү ордыг хулгайгаар хайж эрэгчид байх аваас чангалан барьж монгол бол харьяат чуулганы дарга Эрдэнэ шанздубын яаманд хүргэж нягтлан шийтгэ, гадаад хүн бол Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яам харьяат захирах сайдуудад хүргэж, өөр өөрийн төлөөний түшмэдтэй нийлж нягтлан шийтгэ» хэмээжээ. Харин монголчууд гадаадын хүнийг элсүүлж үйлдсэн уг хэргийг илрүүлж чадаагүй, алдаж зугатаалгасан түшмэлийг огцруулан 100 ташуурдах ба харьяат засгийг нэгэн жилийн пүнлүү хасаж, өөрөө түшмэл гаргаж тус хэргийг бариулахаар заажээ. Хэрэв хэрэг үйлдэгсдийг зориуд тавьж явуулсан түшмэлийг тушаалаас огцруулан 100 ташуурдаж, нэг сар дөнгө дөнгөлүүлэх ба харьяат засгийн 2 жилийн пүнлүүг хасаж шийтгэхээр заажээ [МХТТЭ 2010: 229]. Үүнээс үзвэл, Монголын төр газрын хэвлийн баялгийг зохих зөвшөөрөлгүй хулгайгаар эрж хайх, улмаар олборлох явдлыг таслан зогсоох үүднээс ашигт малтмал бүхий ордыг хянаж цагдах явдлыг хүчтэй болгож байжээ.

Монгол улсын Засгийн газар газрын хэвлийн баялаг ашиглах явдлыг хил хязгаа-

рыг батжуулах, тус улсад дагаар орогчдыг төвхнүүлэхтэй мөн уялдуулж байв. Тухайлбал, Засгийн газрын сайдуудаас Богд хаанд өргөсөн бичигт: «зүүн, баруун, өмнө зүгийн монгол овогтон ...ус мэт дагаар ирсэн...аль болох зохихыг үзэж, харуулын хуучин нутаг газраас зааж олгуулан тохинуулж, ...тэдгээр харьяат газруудын дотор хэрвээ зүйл зүйлийн орд ба эрдэнэ чулууны зэрэг эрхэм хэрэгтэй зүйл буй аваас урьд шийтгэсэн хэргийн ёсоор орос, монгол хэн эрж олж чадах хүнд хугацаа ба хувь тогтоох явдлыг хууль дүрэм хэмжээг мөрдөн дагаж, нэгэн адил шийтгэн олсон ашгийг бүрнээ улсын санд тушаалган туслуулах» [МУДХБЗШЯ 2011: 183–184] санал дэвшүүлснийг Богд хаан ёсоор болгож байв.

Монгол улсын газрын хэвлийн баялгийг ашиглах бодлого боловсроход төрд зүтгэж байсан зүтгэлтнүүдийн санал бодол чухлаар нөлөөлсөнийг Манлай баатар Дамдинсүрэнгээс улс орныг төвхнүүлэх ба хамгаалах талаар өргөсөн айтгалд «...цэрэгт хэрэглэгдэх буу, сум, дарь зэргийг үйлдэхэд хэрэглэх баялгийг нээн ашиглаж, гаднаас зээлэх, гуйх явдалгүй» [Жамсран 1991: 45] хэмээн нээс илэрхий.

Ерөнхий сайд Т. Намнансүрэнгийн санаачлага зүтгэлээр Монгол улсын төрийн байгууламжид Улсын Дээд, Доод хурал хэмээх субъектууд 1914 онд буй болсон билээ. Улсын Дээд хурал «...улс төрийн чухал хэрэгт бодлого гарган зөвлөн хэлэлцээд айлтгах, таслан шийтгэх, Доод хуралд тушаан өгч хэлэлцүүлэх, гүйцэтгэн шийтгүүлэх» [МТЭЗТ 2006: 166], Доод хурал «...улс төрд тустай болох хэрэгт санаа гаргаж зөвлөн хэлэлцээд Дээд хуралд өргөх» [МТЭЗТ 2006: 166] эрх, үүрэгтэй байв. Иймд тус хурлын байгууллагуудын гишүүдээс уул уурхайн талаар дэвшүүлж байсан саналууд төрийн бодлого, үйл ажиллагаанд нөлөө үзүүлэхүйц байсан хэмээн үзэж болно.

Монгол улс газрын баялгийг өөрийн хүчээр нээж, ашиглах хүн хүч, техникийн бололцоогүйн улмаас Хаант Орос улстай хамтран ажиллах бодлогыг барьж, мэргэжилтэн, техникийн тусламж дэмжлэгийг авахыг эрмэлзэж байлаа. Тухайлбал, 1912 оны сүүлч 1913 оны эхээр Эрхүү хотноо Орос-Монголын худалдааны харилцааг хөгжүүлэх тухай асуудал хэлэлцсэн зөвлөлгөөн дээр Гадаад яамны тэргүүн сайд М. Ханддоржоос «Газрын хэвлийд чухам юу байгааг монголчууд бид ер мэддэггүй. Тийм болохоор оросын мэргэжилтнүүд Монгол

нутагт ашигт малтмал эрж хайх, уурхай байгуулахыг бид үнэхээр хүсэж байна» хэмээн мэдэгдэж байжээ [Лонжид 2006: 47].

Үүний хамт Орос улс нь Монгол дахь улс төр, эдийн засгийн эрх ашгаа хамгаалах, бататгах зорилгоор тус орныг бүхий л талаар судлан шинжлэх ажлыг хийж ирсэн бөгөөд энэ удаад ч Монголын санхүүд хяналт тавих, шинэчлэлт хийх, тус орны нийгэм-эдийн засгийн байдлыг судлах зорилгоор С. А. Козиныг 1913 онд санхүүгийн зөвлөхөөр томилж, тэрээр 1914 оны 5дугаар сарын 13-нд Нийслэл Хүрээнд ирж ажилдаа оржээ.

Монгол улсын Засгийн газар С. А. Козиныг ажиллуулахдаа «засгийн аливаа хэргийг зохион байгуулах ба улсын хөрөнгийг захирах хэрэгт зөвлөх түшмэл болохоос гадна, бас улсын засгийн хэргийг шинэтгэн засах дүрэм хэмжээг зохиолгох» [МХТТЭ 2010: 104]-оор тогтжээ. Түүнд улсын хөрөнгө, төсөв орлого, санхүүгийн асуудлуудыг цэгцлэх үүргийг оногдуулсаны дотор улсын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх буюу «*дэлхийн хөрөнгийг шинжлэх явдлыг үүсгэж үйлдэх, ...газар орныг байцаан шинжиж дууссаны хойно эдийн засгийн хэргийг сайжруулан засахыг бодож, хууль дүрэм зохиогоод, сайдуудын чуулганд өргөн барьж, шүүмжлүүлэн батлуулах*» [МХТТЭ 2010:105] явдал багтсан байв.

С. А. Козин улсын төсөв зохиох, орлогын эх үүсвэрийг нэмэх, татвар, гааль, түрээсийг жигдрүүлэх талаар цөөнгүй зүйл санаачилж байсан ч Монголын эрх баригчдын дэмжлэг дутагдаж байжээ. Харин тэрээр Монголын Засгийн газартай байгуулсан гэрээнд заасан ёсоор уул уурхайн талаар даацтайхан санал боловсруулаагүй бөгөөд энэ нь Хаант Оросын үйлдвэр, санхүүгийн эздийн зүгээс өгч байсан чиг бодлоготой холбоотой байсныг үгүйсгэх аргагүй ч үүнд цаг хугацаа, санхүүгийн хүчин зүйлийн нөлөөг тооцож үзэх нь зүйтэй болов уу [Лонжид 2006: 96–97].

Хаант Орос улс ба Монгол улсын Засгийн газарын хооронд 1914 оны 8 сарын 1-нд байгуулсан Зээлийн гэрээнд «...зээлийн зарим хэсгийг газрын баялгийг ашиглах явдал зарцуулахаар тогтсон» [МХТТЭ 2010: 112] ёсоор эхний 600 000 рублийн зээллэгээс 150 000 рублийг ашигт малтмал, аж ахуй санхүүгийн байдлыг судлахад зарцуулахаар С. А. Козин төсөвлөж, Засгийн газраа мэдүүлж байжээ [Лонжид 2006: 38]. Ийнхүү Монгол улс газрын баялгийг аши-

глах, улсын санхүүг нэмэгдүүлэх бодлогыг ажил хэрэг болгоход шаардлагатай хөрөнгө мөнгийг төсөвлөж өгсөн нь зөв зүйтэй шийдвэр байв.

Монголд явуулах судалгааны бэлтгэл ажлын хүрээнд газрын хэвлийн баялгийг тандах багаж хэрэгслийг Орос улсаас авчруулсан байна. Энэ тухай Монголын Сангийн яамны 1915 оны 5 сарын 18-ны бичигт «... орос түшмэл Козиноос газар дэлхийн элдэв ашиг хөрөнгийг шинжлэн үзэх тухай хэрэгсэх элдэв багаж хэрэглэлийг Хиагтын газраас 16 тэргэнд ачиж нэгэн буриад хүнээр харгалзуулан гаргасан нь тав хонож замын өртөөний ачлага эцэгдэж, тэрэг эвдэрч уг эрхэм багаж хэрэглэлийг эвдрүүлэхэд хүргүүлэн бүхий хэмээх тул албаны хүн гаргаж хамт харгалзуулан, ачлага тэргийг сайтгаж тэрхүү багаж хэрэглэлийг эвдрэх хэмхрэхэд хүргэлгүй даруйхан хүргүүлэн ирүүлэх»-ийг Дотоод яамнаа мэдэгдэж [Содбаатар 2013: 137], дээрхи бэлтгэл ажил, багаж төхөөрөмж авахад 7664 руб. 43 коп. зарцуулсан аж [Лонжид 2006: 48].

Ийнхүү 1911–1919 онд Монгол улс уул уурхайн талаар бие даасан бодлого явуулж, улс төр болон эдийн засгийн ашиг сонирхлоо олон улсын тавцанд хамгаалах байр суурийг баримталж байв. Энэ бодлого тус улсын нутагт уул уурхай эрхлэгчидтэй гэрээ байгуулах, тэдний үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх замаар хэрэгжжээ. Чингэхдээ Монгол улс үндэсний эрх ашгийг эн тэргүүнд тавьж, зохих шаардлагыг хангасан дотоод, гадаадын компани, хувь хүмүүст уул уурхай эрхлэх үүд хаалгыг нээж, тэдэнд ажиллах тэгш нөхцөл, боломж бүрдүүлсэн байна. Үүний хамт уул уурхайн үйл ажиллагаа нь хүн ардын суух нутаг орон, малын бэлчээр, эрхэм шүтлэг бүхий газрын дагшин байдлыг алдагдуулахгүй байх зарчмыг баримталжээ. Түүнчлэн Монгол улс газрын хэвлийн баялгаа боловсруулах бодлого явуулаагүй ба тийм ч бололцоо байсангүй.

#### Товчилсон үг (Условные сокращения)

МУУТА — Монгол улсын Үндэсний Төв Архив (Центральный Национальный архив Монголии)  
 Ф А — фонд  
 Д — данс (опись)  
 Хн — хадгаламжийн нэгж (единица хранения)

#### Ашигласан эх сурвалж (Источники)

МУУТА. Ф. А-4. Д. 1. Хн. 2326.  
 МУУТА. Ф. А-4. Д. 1. Хн. 2326.

МУУТА. Ф. А-3. Д. 1. Хн. 20.  
 МУУТА. Ф. А-6. Д. 2. Хн. 16.

#### Баримтын эмхтгэл (Сборник документов)

Котвичийн — Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг. Судлан хэвлүүлсэн акад. Б. Ширэндэв. Улаанбаатар: ШУАХ, 1972. 298 с.  
 МХТТЭ — Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Ерөнхий редактор Б. Чимид. Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2010. 310 с.  
 МАТҮЭЧТТТТ — Монголын ард түмний 1911 оны Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхтгэл (1900–1914). Эмхтгэсэн А. Очир, Г. Пүрвээ. Улаанбаатар: Улсын Хэвлэлийн Газар, 1982. 331 с.  
 МТЭЗТ — Монголын төр эрх зүйн түүх (Дээж бичиг). III дэвтэр. Эмхтгэсэн Б. Баярсайхан, Б. Батбаяр. Улаанбаатар: Соёмбо принтинг, 2006. 210 с.  
 МУДХБЗШЯ — Монгол улсын дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яам (Баримт бичгийн эмхтгэл. 1911–1919 он). Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2011. 505 с.

#### Ашигласан ном (Литература)

Батбаяр Б. Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг (Агуулга, мөн чанар). Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2011. 136 с.  
 Батсайхан О. Монголын тусгаар тогтнол ба Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ (1911–1916). Улаанбаатар: Адмон, 2002. 340 с.  
 Жамсран Л. Жанжин Манлайбаатар Дамдинсүрэн, түүний шинэтгэлийн бодролууд. Улаанбаатар: Шувуун саарал, 1991. 52 с.  
 Лонжид З. Монголын татвар ба алт (1911–1915 он). Улаанбаатар: СЭЛЭНГЭ ПРЕСС, 2011. 412 с.  
 Лонжид З. Монгол улсын санхүүгийн албаны түүх (1911–1921). Улаанбаатар: Содпресс, 2006. 140 с.  
 Сандаг Ш. Монголын улс төрийн гадаад харилцаа. 1850–1919. Боть 1. Улаанбаатар: ШУАХ, 1971. 334 с.  
 Содбаатар Я. Монголын уул уурхайн түүх. Тэргүүн дэвтэр. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК, 2013. 262 с.  
 Туяа С., Баттөмөр Б. Уул уурхай Монгол оронд (Нэн эртнээс XX зууны эх). Улаанбаатар: ЖИКОМ ПРЕСС, 2012. 318 с.  
 Урангуа Ж. Монголын тусгаар тогтнолд Хаант Оросын үзүүлсэн хүчин зүйлс (1911–1917 он). Улаанбаатар: Соёмбо принтинг, 2010. 243 с.  
 Ширэндэв Б. Монгол ардын хувьсгалын түүх (Залруулсан хоёрдахь удаагийн хэвлэл). Улаанбаатар: ШУАХ, 1999. 400 с.

**The Collection of Documents**

- Kotvichijn — Kotvichijn huvijn arhivaas oldson Mongolyn tyyhjend holbogdoh zarim bichig. Sudlan hjevlyylsjen akad. B. Shirjendjev [*Nekotorye dokumenty, obnaruzhenyev lichnom archive V. Kotvicha i imejushhie otnoshenie k mongol'skoj istorii. Opublikovano akad. B. Shirendybom*] [Some documents discovered in the personal archive of V. Kotvich related to Mongolian history. Published by Acad. B. Shirendyb]. Ulan-Bator, ShUAH, 1972, 298 p. (In Mongolian).
- MHTTJe — Mongolyn huul' togtoomzhijn tyyhjen jemhtgjel. Erønhij redaktor B. Chimid. Ulaanbaatar, Mønhiijn ysjeg, 2010. 310 p. [*Sbornik mongol'skih zakonov i normativnyh aktov. Glavnyj redaktor B. Chimid*] [The Collection of Mongolian laws and regulations. Editor in chief B. Chimid]. Ulan-Bator, Mønhiijn ysjeg, 2010, 310 p. (In Mongolian).
- MATYJeChTTTT — Mongolyn ard tymnij 1911 ony Yndjesnij jerh chøløø, tusgaar togtnolyn tøløø tjemcjel. Barimt bichgijn jemhtgjel (1900–1914). Jemhtgjesjen A. Ochir, G. Pyrvjeje [*Bor'ba za svobodu i nezavisimost' mongol'skogo naroda v 1911 g. Sbornik dokumentov (1900–1914). Sostaviteli A. Ochir, G. Pyrvjeje*] [The Struggle for freedom and independence of the Mongolian people in 1911. the Collection of documents (1900–1914). Compiled by A. Ochir, G. Pyurvee]. Ulan-Bator, Ulsyn Hjevjljelijn Gazar, 1982. 331 p. (In Mongolian).
- MTJeZT — Mongolyn tør jerh zyjn tyyh (Djejezh bichig). III djertjer. Jemhtgjesjen B. Bajarsajhan, B. Batbajar [*Istorija prava gosudarstva Mongolii (Hrestomatija). Tetrad' III. Sostaviteli B. Bajarsajhan, B. Batbajar*] [History of the law of the state of Mongolia (the reader). Notebook III. Compiled by Bayarsaikhan B., B. Batbayar]. Ulan-Bator, Sojombo printing, 2006, 210 p. (In Mongolian).
- MUDHBZShJa — Mongol ulsyn dotood hjergijg bygd zahiran shijtjegch jaam (Barimt bichgijn jemhtgjel. 1911–1919 on) [*Rasporjazhenija Ministerstva vnutrennih del Mongolii (Sbornik dokumentov)*]. [Orders of the Ministry of Internal Affairs of Mongolia (the Collection of documents. 1911–1919)]. Ulan-Bator, Mønhiijn ysjeg, 2011, 505 p. (In Mongolian).
- (contents and essence)]. Ulan-Bator, Mønhiijn ysjeg, 2011, 136 p. (In Mongolian).
- Batsaihan O. Mongolyn tusgaar togtnol ba Hjatad, Oros, Mongol gurvan ulsyn 1915 ony Hiagtyn gjerjeje (1911–1916) [*Mongol'skaja nezavisimost' i Kjahtinskij dogovor 1915 g. mezhdru Kitaem, Rossiej i Mongoliej (1911–1916)*] [Mongolian independence and Kyakhta agreement of 1915 between China, Russia and Mongolia (1911–1916)]. Ulan-Bator, Admon, 2002, 340 p. (In Mongolian).
- Lonzhid Z. Mongolyn tatvar ba alt (1911–1915 on). Tyyh søhøhyj. [*Nalog i zoloto Mongolii (1911–1915 gg.) Priotkryvaja istoriju*] [Tax and gold of Mongolia. Uncovering history]. Ulan-Bator, Selenge Press, 2011, 412 p. (In Mongolian).
- Lonzhid Z. Mongol ulsyn sanhyygijn albany tyyh (1911–1921). [*Istorija finansovoj sistemy Mongolii (1911–1921)*] [The history of the financial system of Mongolia]. Ulan-Bator, 2006, 140 p. (In Mongolian).
- Sandag Sh. Mongolyn uls tørijn gadaad harilcaa. 1850–1919. Bot' 1. [*Vneshne-politicheskie otnoshenija Mongolii. 1850–1919. T. 1.*] [Foreign relations of Mongolia. 1850–1919. Vol. 1]. Ulan-Bator, 2006, 140 p. (In Mongolian).
- Sodbaatar Ja. Mongolyn uul uurhajn tyyh. Tjergyyñ djertjer. [*Istorija gornodobyvajushhej promyshlennosti v Mongolii. Kniga 1*] [The History of the mining industry in Mongolia. Book 1]. Ulan-Bator, 2013, 262 p. (In Mongolian).
- Shirendev B. Mongol ardyn huv'sgalyn tyyh (Zalruulsan hojordah' udaagijn hjevjljel). [*Istorija mongol'skoj narodnoj revoljucii (Izdanie 2-e, ispr.)*] [History of the Mongolian People's Revolution (2nd ed-n., revised)]. Ulan-Bator, ShUAH, 1999, 400 p. (In Mongolian).
- Tujaa S., Battømør B. Uul uurhaj Mongol orond (Njen jertnjejes HH zuuny jeh). [*Nedra Mongolii (s drevnejshih vremen do nachala XX v.)*] [Entrails of Mongolia from ancient times to the early 20 century)]. Ulan-Bator, Zhikom Press, 2012, 318 p. (In Mongolian).
- Urangua Zh. Mongolyn tusgaar togtnold Haant Orosyn yzyylsjen hychin zyjl (1911–1917 on). [Faktor carskoj Rossii v stanovlenii nezavisimosti Mongolii (1911–1917)]. [The Role of the Tsarist Russia in Mongolia's independence]. Ulan-Bator, Sojombo printing, 2010, 243 p. (In Mongolian).
- Zhamsran L. Zhanzhin Manlajbaatar Damdinsyrjen, tyyñij shinjetgjelijn bodroluud. [*Voенachal'nik Manlaj Bator Damdinsyrjen i ego novatorskie idei*] [The Commander Manlaj Bator Damdinsyren and his innovative ideas]. Ulan-Bator, Shuvuun saaral, 1991, 52 p. (In Mongolian).

**References**

- Batbayar B. Zarligaar togtooson Mongol ulsyn huul' zyjljin bichig (Aguulga, møn chanar) [*Vysochajshe utverzhdennye ulozhenija Mongol'skogo gosudarstva (Soderzhanie i sushhnost')*] [Constitutions of the Mongolian State ratified by his Majesty



УДК 94(517)

**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ: БАЙР СУУРЬ, БОДЛОГО  
(1911–1919 он)**

**(Горная промышленность Монголии и ее место в политике государства  
(1911–1919 гг.))**

*Янгугийн Содбаатар*<sup>1</sup>

<sup>1</sup> аспирант Монгольского государственного университета образования (Улан-Батор, Монголия).

E-mail: ya\_sod5@yahoo.com

Монгол улс бие даан тусгаар тогтноод, үндэсний эдийн засгаа сэргээн хөгжүүлэхэд чиглэсэн бие даасан бодлогыг 1911–1919 онд явуулсан юм. Тухайн салбар дахь Монголын засгийн газрын бодлого, үйл ажиллагааны нэг чухал чиглэл нь газрын баялгийг ашиглах, түүнээс олох орлогоор санхүүгийн хүндрэлээ шийдэх явдал байв. Энэ зорилгоор Монголын Засгийн газраас тодорхой арга хэмжээнүүдийг, тухайлбал, газрын баялгийг ашиглахтай холбогдсон эрх зүйн актуудыг боловсруулах, «Монголор» нийгэмлэг, Оросын харъяат нартай алт олборлох, орд уурхай нээх концессийн гэрээ байгуулах, тэдний үйл ажиллагаанаас олох татварыг нэмэгдүүлэх зэргээр ажиллажээ. Энэ нь эдийн засгийн ихээхэн ашиг авчраагүй ч Монгол улс үндэсний эрх ашгаа хамгаалахад чухлаар нөлөөлсөн юм.

**Түлхүүр үг:** Тусгаар тогтнол, эдийн засаг, уул уурхай, бие даасан бодлого, улсын санхүү, алт олборлолт, «Монголор».

**Аннотация.** В статье рассматриваются вопросы формирования в 1917 г. Учредительного собрания в соответствии с положением, принятым Временным правительством.

Демократические принципы избирательного права и избирательного процесса, введенные Временным правительством, позволили отдельным национальностям, в том числе и калмыкам, принять активное участие в подготовке и проведении выборов депутатов в Учредительное собрание, а также в реализации пассивного и активного избирательного права. В результате в Учредительном собрании, провозгласившем в начале января 1918 г. Россию демократической федеративной республикой, калмыцкий народ впервые был представлен в высшем органе законодательной власти страны двумя своими депутатами. Однако России не было суждено пойти по определяемому Учредительным собранием пути.

Почти через 75 лет Россия вынуждена была вернуться на путь демократического федеративного правового государства с республиканской формой правления, к тому, что пыталось заложить Учредительное собрание.

**Ключевые слова:** Временное правительство, Положение о выборах, Учредительное собрание, демократизация, избирательное право, избирательный процесс, избирательный участок, округ, Область войска Донского, Прикаспийский, станица, улус, национальный регион, калмыки.